

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 05 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 13 цаг 45 минутад эхэлж, 16 цаг 40 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг 55 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Албаны орон сууц эзэмшүүлэх журам, эзэмшүүлэх гэрээний загварын төсөл хэлэлцүүлэх тухай	Албаны орон сууц эзэмшүүлэх журам, эзэмшүүлэх гэрээний загварын төсөл хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн мэргэжилтэн Б.Бурмаад үүрэг болгов.
2	Амины орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тухай	1.Орон нутгийн концессын зүйлийн жагсаалтад амины орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ барих талаар нэмж тусгахыг Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Эрхбаярт 2.Амины орон сууцыг иргэдэд олгох журам боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад 3.Амины орон сууцны хороололын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тухай хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад тус тус үүрэг болгов.
3	“Шим ус”, “Ховд Эрч хүч”, “Ховд суварга” ОНӨААТҮГ-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл	1.Айл өрх тус бүрийг усыг тоолууржуулах арга хэмжээ авахыг “Шим ус” ОНӨААТҮГ-ын дарга Д.Нямлхагвад 2.“Шим ус”, “Ховд Эрч хүч”, “Ховд суварга” ОНӨААТҮГ-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл хэлэлцэх явцад гарсан саналын дагуу санхүүгин үйл ажиллагаанд Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргаар ахлуулан аймгийн Аудит, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба, Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Баасанхүү, Хар нуур Ховд голын сав газрын захиргааны холбогдох мэргэжилтэн

		<p>нарыг оролцуулсан ажлын хэсэг байгуулж, дахин танилцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатарт</p> <p>3.Төсвийн жил гарахаас өмнө аймгийн төсөвтэй хамт “Шим ус”, “Ховд Эрч хүч”, “Ховд суварга” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, гэрээ байгуулж байхыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатар, Хяналт-шинжилгээ үнэлгээний тасгийн мэргэжилтэн Б.Бурмаа нарт</p> <p>4. “Шим ус”, “Ховд Эрч хүч”, “Ховд суварга” ОНӨААТҮГ-ын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг дэмжиж, ажлын хэсгийн дахин танилцуулсан саналын дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатарт тус тус үүрэг болгов.</p>
4	Ховд аймагт Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх тухай танилцуулга	<p>Ховд аймагт Хэвлэл мэдээллийн тогтвортой хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гарсан саналын дагуу олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрт албан бичгээр уламжлахыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Дэлгэрбаярт үүрэг болгов.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 06 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 16 цаг 15 минутад эхэлж, 16 цаг 45 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 30 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Ховд хотын 330 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хороо байгуулах тухай	Ховд хотын 330 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хороо байгуулах тухай төслийг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Ганболдод үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 07 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 10 цаг 50 минутад эхэлж, 13 цаг 10 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг 20 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Ховд аймгийн сумдын хилийн цэсийг баталгаажуулах тухай	1.Ховд аймгийн Буянт, Ховд сумдын хилийн цэсийг Багийн Иргэдийн нийтийн хурал, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж дахин Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах 2.Ховд аймгийн бусад сумдын хилийн цэсийг баталгаажуулах тухай саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад үүрэг болгов.
2	Улсын чанартай авто зам дагуух Монгол улсын иргэнд өмчлөх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулалтын тухай	Улсын чанартай авто зам дагуух Монгол улсын иргэнд өмчлөх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулалтын тухайсаналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад үүрэг болгов.
3	Иргэнд шинээр газар өмчлүүлэх тухай	Иргэнд шинээр газар өмчлүүлэх тухай саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад үүрэг болгов.
4	Баруун бүсийн барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн үнэ тарифыг батлуулах тухай	Баруун бүсийн барилгын материалын сорилт, шинжилгээний лабораторийн үнэ тарифыг батлуулах тухай саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад үүрэг болгов.

5	Газар тариалан дэд хөтөлбөр	Газар тариалан дэд хөтөлбөрийн төслийг дахин хэлэлцэж, саналыг тусган аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Ц.Пүрэвсүрэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга З.Лувсан нарт үүрэг болгов.
6	Мал эмнэлэг үржлийн шинэчилсэн үнэ тарифын тухай	Мал эмнэлэг үржлийн шинэчилсэн үнэ тарифыг хэлэлцэх явцад гарсан саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга З.Лувсан нарт үүрэг болгов.
7	БНХАУ-ын ШУӨЗ Орны Алтай аймаг болон Монгол улсад суугаа БНХАУ-ын элчин сайдын яамнаас өгсөн хандив тусламжийн тухай	Хуульд нийцүүлэн санал боловсруулж Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатар, Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бат-Очир нарт үүрэг болгов

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 08 ДУГААР ХУРАЛ**

2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 16 цаг 30 минутад эхэлж, 19 цаг 10 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын өрөөнд болж, нийт 2 цаг 40 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн газар зохион байгуулалтын 2015 оны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	<p>1.Жишиг хороололд газар хүссэн иргэдэд газар өгч, хашаа барихыг зөвшөөрөх</p> <p>2.Хайрхан багийн замын дагуу газрын төлөвлөлтийг хийх</p> <p>3.Хогийн талбайд газар нэмж төлөвлөж, иргэн хогоо цэвэрлээд давуу эрхээр эзэмших</p> <p>4.МАХН-ын байрны газрыг дахин ярилцаж иргэний хувийн сууцтай зэрэгцүүлэн төлөвлөх</p> <p>5.Малчны хороололд газар төлөвлөх</p> <p>6.Хорихын хамгаалалтын бүсийг дахин тогтоож яаралтай нүүлгэн шилжүүлэх талаар албан бичиг төлөвлөх зэрэг саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулгад</p> <p>1.2.Жишиг хороололын зарчмаар малчны хороололд олгож байгаа газрыг тэгш олгож зургийн дагуу төлөвлөлт хийж газар олгохыг Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Нямтулга, Жаргалант сумын Засаг даргад, газрын даамалууд нарт тус тус үүрэг болгов.</p>
2	Жаргалант сумын нутагт байрлах соёлын өвийн үл хөдлөх дурсгалд хамаарах “Шар сүм”-ийн туурь орчмын газрыг орон нутгийн хамгаалалтад авах тухай	<p>1.Жаргалант сумын нутагт байрлах соёлын өвийн үл хөдлөх дурсгалд хамаарах “Шар сүм”-ийн туурь орчмын газрыг орон нутгийн хамгаалалтад авах</p> <p>2.Сангийн хэрэм, Ховд хотын туурийг орон нутгийн хамгаалалтад авах гишүүдийн саналыг тус тус дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Аймгийн Засаг даргын орлогч Ч.Чинбат, Жаргалант сумын Засаг дарга Д.Баасандорж нарт үүрэг болгов.</p>

3	<p>“Мянган угалзат” ОНӨААТҮГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй уурын зуухны барилга, тоног төхөөрөмжийн тухай</p>	<p>1.“Мянган угалзат” ОНӨААТҮГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй уурын зуухны барилганд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гаргуулж авах</p> <p>2.“Мянган угалзат” ОНӨААТҮГ-ын хөрөнгөнд бүртгэлтэй уурын зуухны яндангуудыг “Ховд-Эрч хүч” ОНӨААТҮГ-т шилжүүлэн ногоон байгууламжийн зориулалтаар ус дамжуулахад ашиглах</p> <p>3.52 айлын орон сууц хүртэлх дулааны шугамыг Дулааны 2-р станцад, бусад шугамыг “Шим ус” ОНӨААТҮГ газарт шилжүүлэх</p> <p>4.Уурын зуухнуудыг Дуут, Эрдэнэбүрэн сумын ЕБСургуулиуд саналаа ирүүлсэний дагуу холбогдох байгууллагад данснаас дансанд шилжүүлэх</p> <p>5.“Ховд-Эрч хүч” ОНӨААТҮГ газарт 2 ш насос, “Шим ус” ОНӨААТҮГ газарт 1 ш насосыг тус тус данснаас дансанд шилжүүлэн ашиглуулах талаарх саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний тасгийн мэргэжилтэн Б.Бурмаад үүрэг болгов.</p>
4	<p>Орон нутгийн концессын зүйлийн жагсаалтын тухай</p>	<p>Орон нутгийн концессын зүйлийн жагсаалтын 12 дугаар хэсгийн сумдад гэж өөрчлөх, хөрөнгө оруулалтыг 200 сая төгрөг гэснийг 300 сая гэж өөрчлөх</p> <p>2.Жагсаалтын 8, 15. 16. 21. 22 дэх хэсгийг хасах</p> <p>3.Жагсаалтын 22 дахь хэсэгт ЕБС-ийн 7-р сургууль, 9-р цэцэрлэг гэж өөрчлөх</p> <p>4.1-р цэцэрлэгийг шинээр барих, 8,9,10 дугаар цэцэрлэгийн өргөтгөл, Жаргалант сумын Соёл урлаг спортын цогцолбор барих гэж нэмж тусгах</p> <p>5.Аймгийн Засаг даргын орлогч Ч.Чинбат, Ерөнхий Аудитор Л.Галбадрах \зөвшилцсөнөөр\ Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бат-Очир нарын бүрэлдхүүнтэй ажлын хэсэг гарч дахин эцсийн байдлаар нягталж, саналуудыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон</p>

		гүйцэтгэгч Б.Бат-Очирт үүрэг болгов.
5	БНХАУ-ын ШУӨЗОрны Алтай аймаг болон БНХАУ-ын элчин сайдын яамнаас өгсөн хандив тусламжийн тухай	<p>1.Монгол улсад суугаа БНХАУ-ын элчин сайдын яамнаас өгсөн 100.0 мянган юаний хандивыг Улаанбаатар хотод болох соёлын өдрүүд болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон БНХАУ-ын ШУӨЗОрон Ховд аймгийн соёлын өдрийн арга хэмжээнд 30 сая төгрөгийг</p> <p>2.Биеийн тамир спортын талбайн барих хөрөнгийг сольж 90 сая төгрөгийг шилжүүлж, оронд нь авсан 90 сая төгрөгийг аймгийн гэрэлтүүлэг хийхэд зарцуулах</p> <p>3.Хандив өгөхөд ирсэн зочдын буудалд байрласан 2470000 төгрөгийг дансанд байршуулсан юанийн ханшийн зөрүүнээс зарцуулахаар тооцох саналыг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга П.Амгаланбаатар үүрэг болгов.</p>
6	Хөрөнгө гаргах захирамжийн төсөл тухай	Хөрөнгө гаргах захирамжийн 1935950 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг зөвшөөрч олонхийн саналаар дэмжив.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР